# САНХҮҮ БҮРТГЭЛ ХАМРАЛТ ОРЛОГЫН ХЭЛТСИЙН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв /мян.төг/ | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт*** | | | | | | | |
| *“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 1.1.1 | Нийгмийн даатгалын багц хууль /шинэчилсэн найруулга/-ийг хэрэгжүүлэхтэй холбоотой шинээр батлагдсан дүрэм, журам, дээд газраас ирүүлсэн заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг зохион байгуулах. | Шаард-лагагүй | Хэрэгжүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн тоо | Нийгмийн даатгалын хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбоотой НДЕГ-аас 2023 онд ирүүлсэн 12 удаагийн зөвлөмжийн хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулсан | Дээд газраас ирүүлсэн дүрэм, журам, заавар, зөвлөмж, аргачлал, чиглэлийн хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж, үр дүнг тооцож ажилласан байна | -Хуулийн шинэчилсэн найруулгатай уялдан гарсан дараах заавар журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллалаа. Үүнд:<br>-Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журмын дагуу ажил олгогч байгууллагуудаас ирүүлж буй даатгуулагчийн төрөл андуурсан, ХХТАОрлого зөрүүлсэн, буруу тайлагнасан гэх мэт 46 аж ахуйн нэгж байгууллагуудын хүсэлтийг хүлээн авч Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасны дагуу холбогдох арга хэмжээг авч шийдвэрлэсэн,.<br>-Нийгмийн даатгалын сайн дурын даатгалд хөдөлмөрийн хөлснөөс дээд хэмжээгээр даатгуулах хүсэлтэй иргэдэд мэдээлэл хүргэж хуульд заасны дагуу 4620,0 мянган төгрөгийн хөдөлмөрийн хөлсөөр гэрээ байгуулах зөвлөгөөг 30 гаруй даатгуулагчид өгч 16 сайн дурын даатгалын гэрээг баталгаажуулсан,<br>-Эрүүл мэндийн даатгалын | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шимтгэлийн хувь хэмжээ, хураамж төлүүлэх тухай чиглэлийн дагуу тус байгууллагаар үйлчлүүлсэн 800 гаруй иргэдэд заавар зөвлөгөө өгч шимтгэлийг Ebarimt ашиглан төлүүлсэн,<br>-Нийгмийн даатгалын ерөнхий хуульд заасан тэтгэвэр тогтоолгон авч байгаа иргэн гэрээний дагуу ажиллаж байгаа тохиолдолд нийгмийн даатгалын шимтгэлийг хэрхэн төлүүлэх тухай чиглэлийг ажил олгогч байгууллагын төлөөлөл, удирдах ажилтны шуурхай хуралдаанд танилцуулж ажилласан. Мөн ҮЭХолбооноос зохион байгуулсан 2 удаагийн сургалтад 100 гаруй нягтлан бодогчдод мэдээлэл зөвлөгөө хүргэсэн,<br>-Нийгмийн даатгалд шинээр бүртгүүлсэн 117 ажил олгогчоос шимтгэл төлөгчөөр бүртгүүлэх тухай албан хүсэлт холбогдох бусад материалыг хүлээн авч бүртгэн, ажил олгогчийн хувийн хэргийн бүрдлийг баяжуулсан,<br>-ҮОМШӨний даатгалын санд шимтгэл төлөх ажил мэргэжлийн жагсаалтын дагуу ажил олгогч байгууллагуудад шимтгэлийн тооцоог хэрхэн тайлагнах тухай ZOOM сургалт хийж танилцуулан ажилласан,<br>Хууль тогтоомж, мэдээллийн сангийн шинэчлэлттэй холбоотой 30 гаруй чиглэл заавар зөвлөмж ирснийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. | |
| 1.1.2 | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх, малчид, албан бус хөдөлмөр эрхлэгчдийг сайн дурын даатгалд шинээр хамруулах, | Шаард-лагагүй | Сайн дурын даатгалд шинээр хамруулсан даатгуулагч (малчин)-ийн тоо, дээд газарт | 2023 онд 610 хүнийг сайн дурын даатгалд шинээр, үүнээс 245 малчин | Сайн дурын даатгалд 2024 онд 559 даатгуулагч, үүнээс 110 малчин даатгуулагчийг шинээр хамруулж, хамралтын төлөвлөгөөг | Сайн дурын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх талаар дараах ажлуудыг зохион байгуулан ажиллалаа. Үүнд: Аймгийн БОЭТөвд амаржсан эхчүүдийн судалгааг эрүүл мэндийн мэргэжилнээр нь гаргуулж нийгмийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | | хүргүүлсэн мэдээ, тайлангийн тоо | шинээр хамруулав | биелүүлсэн байна. | даатгалын ач холбогдлыг сурталчилан таниулахаар харилцах утсаар нь холбогдон 334 даатгуулагчдад мэдээлэл хүргэсэн,<br>-Хэрлэн сумын багуудын ажлын албанд хандаж иргэдийн судалгаанд үндэслэн зорилтот бүлгийг сонгож мэдээлэл хийж ажилласнаар<br>Малчин даатгуулагч -68,<br>0-3 хүртлэх насны хүүхэдтэй ажил хөдөлмөр эрхлээгүй ээж -48,<br>Энгийн сайн дурын даатгалд -45 иргэнийг шинээр хамруулсан үзүүлэлттэй байна.<br>-Хөдөлмөрийн гэрээгээ цуцалж ажилгүй болсон даатгуулагчдад сайн дурын даатгалын талаар тусгайлсан зөвлөгөө өгч ажилласны үр дүнд ажилгүйдлийн тэтгэмж авч байгаа 53 даатгуулагчийг сайн дурын даатгалд хамруулсан.<br>-Хөдөлмөр халамжийн газраас “Цалинтай ээж” хөтөлбөрт хамрагдаж байгаа эхчүүдийн судалгаанд үндэслэн 106 эхийг тус тус хамруулсан байна.<br>-Малчдыг нийгмийн даатгалд хамруулах ажлын хүрээнд сум тус бүрт тооны төлөвлөгөө өгч үр дүнг тооцон ажиллаж байна<br>Тайлант хугацаанд нийгмийн даатгалын сайн дурын даатгалд<br>Малчин даатгуулагч – 82,<br>0-3 хүртлэх насны хүүхэдтэй эх – 58,<br>Энгийн сайн дурын даатгал- 98,<br>ХБ хүүхдээ асарч буй эцэг, эх- 86<br>Бүгд 324 даатгуулагчийг хамруулж гүйцэтгэл 67,7 хувийн биелэлттэй байна. | |
| 1.1.3 | Албан журмын даатгалын хамралтыг нэмэгдүүлэх зорилгоор нийгмийн даатгалд хамрагдаагүй | Шаард-лагагүй | Албан журмын даатгалд шинээр хамрагдсан ажил олгогч, албан | 2023 онд 146 ажил олгогч, 465 хүнийг албан журмын | Ажил олгогчийн тоог 40, даатгуулагчийн тоог 219 нэмэгдүүлж, төлөвлөгөөг биелүүлсэн | Аймгийн Татварын хэлтэст цалин хөлс, түүнтэй адилтгах орлогын тайлан өгч байгаа аж ахуйн нэгж байгууллагын судалгааг авч нийгмийн даатгалд | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | ажил олгогч, даатгуулагчдыг шинээр хамруулах, хамралтын төлөвлөгөөг биелүүлэх ажлыг зохион байгуулах, биелэлтийг тогтоосон хугацаанд хүргүүлэх. | | журмын даатгуулагчийн тоо | даатгалд шинээр хамруулав | байна | хамрагдах талаар зөвлөгөөг тогтмол өгч ажиллаж байна. Тайлангийн хугацаанд 111 ажил олгогчийн 223 албан журмын даатгуулагчийг хамруулсан байна. Нийгмийн даатгалын хамралтыг нэмэгдүүлэх А/61 тушаалын биелэлтийг гаргасан тайланг тогтоосон хугацаанд нь хүргүүлэн ажилласан. Албан журмын даатгалын хамрагдалт ажил олгогчийг 100 хувь, даатгуулагчийг 46,6 хувийн гүйцэтгэлтэй хамруулсан байна. | | |
| ***Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | | |
| *"Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | | |
| 2.1.1 | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн тухай хууль, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын сангийн 2024 оны орлого, зарлагын гүйцэтгэл | Нийгмийн даатгалын санд 2023 онд 48,558.6 төгрөгийн орлого төвлөрүүлж, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардалд 103,263.5 төгрөг зарцуулсан | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна | ***Сангийн орлого***: Тэтгэврийн даатгалын санд 52567002.8 мянган төгрөг, Тэтгэмжийн даатгалын сангийн орлого 5527571 мянган төгрөг, ҮОМШӨ даатгалын сангийн орлого 4722923.7 мянган төгрөг, Ажилгүйдлийн санд орлого 1043047.36 мянган төгрөгийн орлогыг тус тус оруулах урьдчилсан гүйцэтгэл гаргаад байна. ***Сангийн зарлага:*** Нийгмийн даатгалын сангаас хуульд заасан үндэслэлээр олгогдох тэтгэвэр, тэтгэмж төлбөр зардалд 135491944.1 мянган төгрөг зарцуулахаас 134162907.75 мянган төгрөгийг зарцуулж 1329036.35 мянган төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна. Батлагдсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлийг гаргаж үзэхэд орлогын төлөвлөгөө 100.7 хувиар, зарлагын төлөвлөгөөг төсвийн хуваарийн дагуу | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэтрүүлээгүй ажиллаж байна.<br>Нийгмийн даатгалын ер[illegible]хий газрын даргын тушаалаар батлагдсан төсвийн хуваарийн дагуу нийгмийн даатгалын сангийн 63379295.1 мянган төгрөгийн орлого, 135491944.1 мянган төгрөгийн зарлагын төсвийн хуваарийг сум тус бүрээр нарийвчилсан хуваарилалтыг хийсэн. | |
| 2.1.2 | Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хууль, НДЕГ-ын даргын баталсан нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн нарийвчилсан хуваарь, сар, улирлын хуваарийг мөрдөж ажиллах. | Шаард-лагагүй | Нийгмийн даатгалын байгууллагын 2024 оны үйл ажиллагааны урсгал зардлын төсвийн гүйцэтгэл | Нийгмийн даатгалын байгууллагын 2023 оны үйл ажиллагааны урсгал зардалд 1057,6 сая төгрөг зарцуулсан. | Батлагдсан төсвийн хуваарь, дээд газраас ирүүлсэн зөвлөмж, чиглэлийг мөрдөж ажилласан байна | Үйл ажиллагааны урсгал зардалд 1,724,312.4 мянган төгрөг батлагдсанаас нийт 1,601,186.14 мянган төгрөгийг зарцуулж 81,928.5 мянган төгрөгийг хэмнэн 92.8 хувийн гүйцэтгэлтэй байна. Үүнд:<br>- Цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал, унаа хоолны хөнгөлөлтөд 1,193,798.2 мянган төгрөг батлагдсанаас 1,165,578.61 мянган төгрөг,<br>- Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлд 144,796.0 мянган төгрөг батлагдсанаас 140,741.01 мянган төгрөг,<br>- Байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 15,619.3 мянган төгрөг батлагдсанаас 10,839.94 мянган төгрөг,<br>- Хангамж бараа материалын зардалд 19,861.8 мянган төгрөгнөөс 9,614.4 мянган төгрөг,<br>- Эд хогшил урсгал засварын 11,878.7 мянган төгрөг батлагдсанаас 10,503.7 мянган төгрөг,<br>- Дотоод албан томилолтын зардал 9,922.1 мянган төгрөг батлагдсанаас 3,276 мянган төгрөг,<br>- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний төлбөр, хураамж 4,074.1 мянга төгрөг батлагдсанаас 565.092 мянган төгрөг,<br>- Гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардал 4,455.0 мянган төгрөг батлагдсанаас 2,847.9 мянган төгрөг,<br>- Эмнэлэг хөдөлмөр магадлал комисс, гомдлын шаардлагын зөвлөлийн зардалд 68,753 мянган төгрөг батлагдсанаас 46,633.38 мянган төгрөг,<br>- Бусад ажил олгогчоос олгох бусад тусламж дэмжлэг, тэтгэвэрт гарахад олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай 5 дээш жил ажилласан албан хаагчдад олгох тэтгэмж урамшуулал 236,237.3 мянган төгрөг батлагдсанаас 234,623.55 мянган төгрөгийг тус тус батлагдсан төсөвтөө багтаан эдийн засгийн ангилал, зориулалтын дагуу зарцуулсан. | |
| 2.1.3 | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх. | | Батлагдсан 59 473 877.30 төгрөгийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөний биелэлтийг сараар, өссөнөөр жигд биелүүлэн ажиллана. | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын сангийн орлогыг 48 620 383.75 төгрөгөөр буюу 94.2 хувиар | Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн даатгалын санд эхний хагас жилийн байдлаар 28 782 300,0 төгрөгийн орлого төвлөрүүлсэн байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/202 тоот тушаалаар баталсан төсвийн тодотгосон хуваариар энэ онд нийгмийн даатгалын санд 63379295,1 мянган төгрөгийн орлого төвлөрүүлэхээр батлагдсан.<br>Сангийн орлого жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 63860544,8 мянган төгрөгийн шимтгэлийн орлого цуглуулж сангийн орлогын төлөвлөгөөг 100,7 хувиар биелүүлэн ажиллаж байна.<br>Шимтгэлийн орлогыг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 15301891,34 | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | биелүүлсэн | | мянган төгрөг буюу 31,5 хувиар нэмэгдсэн үзүүлэлттэй ба[illegible]а. | |
| 2.1.4 | ЭМДЕГ-аас ирүүлсэн эрүүл мэндийн даатгалын сангийн ажил олгогчийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх. | | ЭМДЕГ-аас ирүүлсэн орлогын төлөвлөгөө биелсэн байна. | ЭМД-ын сангийн орлого 9 634 037.62 төгрөг төвлөрсөн байна. | ЭМД-ын сангийн орлогын төлөвлөгөө 100 хувь биелсэн байна. | Нийгмийн даатгалын албан журмын даатгалд даатгуулсан 18223 даатгуулагчийн ажил олгогч даатгуулагчаас төлсөн 12691156.7 төгрөгийн шимтгэлийн орлого оруулахаар байна. Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газрын А/15 дугаар тушаалаар 13049325,2 төгрөгийн орлого оруулах төлөвлөгөөтэй байсан ба гүйцэтгэл 97,3 хувийн биелэлттэй байна. | |
| 2.1.5 | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах ажлыг зохион байгуулж оны эхний үлдэгдэлээс бууруулах, үр дүнг тооцож хэлтсийн даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх. | | Ажил олгогчоос төлөх шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30-аас доошгүй хувиар бууруулна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлага оны эхнээс 39.78 хувиар өссөн байна. | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн авлагыг оны эхний дүнгээс 30 хувиас доошгүй буурсан байна | 2023 оны жилийн эцсээр байдлаар 1628441.6 мянган төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг үүссэн хугацаагаар нь ангилж "Нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийг тайлагнах, шимтгэлийг нөхөн төлүүлэх журам"-д заасан шимтгэлийн өр барагдуулах ажлыг шат дараатайгаар зохион байгуулан ажиллаж байна. Нийгмийн даатгалын шимтгэлийн өр барагдуулах талаар дараах арга хэмжээг авч ажиллаж байна.<br>Үүнд: Ажил олгогчийн шимтгэлийн өрийг заасан хугацаанаас хойш төлөгдөөгүй хугацаагаар нь ангилан газрын даргаар батлуулсан "Нийгмийн даатгалын хамрагдалтыг нэмэгдүүлж авлага бууруулах аян"-ыг зохион байгуулан нийт байцаагч ажилтнуудыг 6 багт хуваарилан ажил олгогч нэг бүртэй уулзан албан шаардлага, мэдэгдэл дансны зарлагын гүйлгээ зогсоох тухай мэдэгдлийг тус бүр хүргүүлж байсан.<br>• Үүнд: 455 аж ахуйн нэгж байгууллагын захирал болон нягтлан бодогч нартай утсаар болон биеэр уулзан албан шаардлага хүргүүлж цаашид өр авлага | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үүсгэхгүй байх талаар хууль тогтоомжид заасан мэд элэл өгсөн,<br>• 92 аж ахуйн нэгж байгууллагад албан шаардлага хүргүүлснээр 924.8 сая төгрөгийг,<br>• 9 аж ахуйн нэгжид 2,480.3 сая төгрөгийг,<br>• 399 аж ахуйн нэгж байгууллагын банкин дахь харилцах дансны зарлагын гүйлгээг зогсоож 113 байгууллагын 1376,4 сая төгрөгийг,<br>• 9 аж ахуйн нэгж байгууллагатай гэрээ байгуулж 6 аж ахуйн нэгжийн 770.7 сая төгрөгийг,<br>• 395.5 сая төгрөгийн шимтгэлийн өр үүсгэсэн 12 аж ахуйн нэгж байгууллагыг хуулийн байгууллагад шилжүүлэн 1 байгууллагын шүүхийн захирамжыг гаргуулан 74.0 сая төгрөгийг тус тус барагдуулан ажилласан байна.<br>Энэ ажлыг зохион байгуулснаар оны эхний үлдэгдлийг 528.0 сая төгрөг хүртэл бууруулж шинээр үүсээд байсан шимтгэлийн өрийг 449.3 сая төгрөffj авлагыг бууруулан ажилласан байна.<br>2024 оны жилийн эцэст урьдчилсан байдлаар 1500,0 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөр үүсэх урьдчилсан гүйцэтгэл гарч байна. | |
| 2.1.6 | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөгийг барагдуулах | | Сайн дурын даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөггүй гарсан байна. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог хийсэн. | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, өглөггүй байна. | Сайн дурын дааатгуулагчаас нийгмийн даатгалын шимтгэлийн авлага байхгүй болно. Оны эхний байдлаар нийгмийн даатгалын санхүүгийн тайланд 1317 сайн дурын даатгуулагчдад 26882,5 сая төгрөгийн нийгмийн даатгалын шимтгэлийн өглөг тусгагдсан. Дээрх өглөгөөс 42 хувь буюу 17591,85 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлд ногдуулалт хийж 4325,0 мянган төгрөгийг 32 даатгуулагчийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | өргөдөлд үндэслэн буцаалт хийж 4965,5 мянган төгрөгийн тооцооны үлдэгдэлтэй байна. | |
| 2.1.7 | Бусад өглөг, авлагыг барагдуулах | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн өглөг авлагаас бусад өглөг, авлагыг хугацаанд нь барагдуулна. | Бусад өглөг авлага санхүүгийн тайлангаар баталгаажсан байна. | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг оны эхний дүнгээс 50 хувиас доошгүй барагдуулах.<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг бүрэн барагдуулах. | а)2023 оны жилийн эцсийн байдлаар үүссэн нийгмийн даатгалын сангийн бусад өглөг 1962,7 мянган төгрөг үүссэнээс 1880,7 мянган төгрөг буюу 95,8 хувийг барагдуулсан байна.<br>Бусад авлага 7054,7 мянган төгрөгийн тооцоо нийлсэн актаас 6985,8 мянган төгрөгийг барагдуулаад байна.<br>Дээрх тооцооны үлдэгдлийг оны эцэст хувиар 96,2 барагдуулж ажилласан болно. | |
| 2.1.8 | НДЕГ-ын даргын 2023.12.26-ны өдрийн А/183 тоот тушаалаар батлагдсан "Нийгмийн даатгалын шимтгэлийн орлогыг төвлөрүүлэх, хуваарилах, санхүүжилт олгох, хяналт тавих журам"-ын 3.3 дах заалтыг хэрэгжүүлж ажиллах. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлнэ. | | НДЕГ-ын төвлөрсөн орлогын харилцах дансанд өдөр бүр бүрэн төвлөрүүлсэн байна. | Сангийн өдөр бүрийн чөлөөт үлдэгдлийг нийгмийн даатгалын ерөнхий газрын төвлөрсөн орлогын харилцах дансанд 4 сарыг дуустал өдөр бүр төлбөрийн хүсэлт бичиж төвлөрүүлэн ажилласан бөгөөд 5 сараас арилжааны банкнаас шууд төвлөрүүлэлт хийгддэг болсон.<br>Төрийн сангаар хийгдсэн 41973730,64 мянган төгрөгийн орлогын гүйлгээг төрийн сангийн удирдлагын цахим системийг ашиглан 71 удаа төвлөрүүлэн ажиллаж байна.<br>Нийт 74895537,1 мянган төгрөгийн шимтгэлийн орлогыг 5 арилжааны банк, Төрийн сангаар төвлөрүүлж журмын хэрэгжилтийг хангаж ажилалаа. | |
| 2.1.9 | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах. | | Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад 138 283 056.60 төгрөгийн тэтгэвэр тэтгэмж төлбөр зардлыг хугацаанд нь олгоно. | Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан. | а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төсвийн дагуу 138 283 056.60 төгрөгийг хуульд заасан хугацаанд зарцуулсан | Сангийн зардлын батлагдсан төсвийн хуваарийн дагуу жилийн эцсийн байдлаар 135491944 мянган төгрөгийн зардал төсөвлөснөөс 134162907.75 мянган төгрөгийг тэтгэвэр, тэтгэмжийн сангаас холбогдох зардлуудыг шилжүүлж олгосон.<br>**Тэтгэврийн даатгалын сангаас:**<br>2024 оны тайлант улиралд тэтгэврийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байна | даатгалын сангаас өндөр насны, тахир дутуугийн , тэжээгч алдсаны, цэргийн албан хаагчийн тэтгэвэр авч байгаа 15079 тэтгэвэр авагчидад **123491273,5** мянган төгрөгийг зарцуулсан.<br>Үүнд:<br>Өндөр насны тэтгэвэр 11367 авагчдад – 90786407,7 мянган төгрөг,<br>Тахир дутуугийн 2408 тэтгэвэр авагчдад- 17056600,3 мянган төгрөг,<br>Тэжээгч алдсаны 575 тэтгэвэр авагчдад- 4254604,8 мянган төгрөг,<br>Цэргийн 729 тэтгэвэр авагчдад- 11393660,7 мянган төгрөгийн тэтгэвэр тус тус олгосон байна.<br>***<u>Тэтгэмжийн сангаас:</u>***<br>Хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэмжид 2570 даатгуулагчид 518035.7 мянган төгрөг зарцуулсан.<br>Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад тэтгэмжийн зардал 97.3 мянган төгрөг буюу 23,1 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br><br>Жирэмсэн амаржсаны тэтгэмжид 1332 даатгуулагчид 3915532,9 мянган төгрөг,зарцуулсан.<br>Жирэмсэн амаржсаны тэтгэмж өмнөх оны мөн үетэй харьцуулбал 1296080,0 мянган төгрөг буюу 49,5 хувиар нэмэгдсэн үзүүлэлтэй байна.<br><br>Нас барсан даатгуулагчийн гэр бүлийн гишүүнд олгох тэтгэмж 398 даатгуулагчдад 796000,0 мянган төгрөг, тус тус зарцуулсан байна.<br>Үүнийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал оршуулагын тэтгэмжийн зардал 60000,0 мянган төгрөг буюу 7,7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.<br>***<u>Ажилгүйдлийн даатгалын сангаас:</u>*** | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Ажилгүйдлийн тэтгэмжид хүлээгдэж буй гүйцэтгэлээр 574 даатгуулагчид 2147544,0 мянган төгрөгийг ажилгүйдлийн тэтгэмжид олгосон байна.<br>Ажилгүйдлийн тэтгэмжийн зардал өмнөх онтой харьцуулахад 569970,3 мянган төгрөг буюу 36,1 хувиар нэмэгдсэн дүнтэй байна.<br>*<u>ҮОМШӨ-ний даатгалын сангаас :</u>*<br>Тахир дутуугийн тэтгэвэр авагч 44 иргэнд 469119,3 мянган төгрөг,<br>Тэжээгч алдсаны тэтгэвэр авагч 12 иргэнд 82714,61 мянган төгрөг,<br>ҮОМШӨ-ний даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсан 11 даатгуулагчдад 78935,0 мянган төгрөгийг олгосон. | |
| 2.1.10 | Батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах. | | Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулахгүй, ажиллагсадтай холбоотой болон бусад өр авлагагүй ажиллана. | Батлагдсан 1 206 306.80 төгрөгийн төсвийг зардлын ангиллын дагуу 1 140 822.43 төгрөг зарцуулсан. | )Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх.<br>б)Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>в) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгээгүй байна. | 1) Холбогдох хууль тогтоомжийн дагуу дараах урсгал үйл ажиллагааны зардлуудыг хэмнэн ажиллалаа. Үүнд:<br>-Байгууллагын халаалтын системийн үйл ажиллагааг сайжруулж засвар үйлчилгээ хийж ажилласны үр дүнд түлш халаалтын зардалд 7223,5 мянган төгрөг батлагдсанаас 4700,0 мянган төгрөгийг зарцуулж 2523,5 мянган төгрөгөөр,<br>- Албан хэрэг хөтлөлт болон холбогдох бусад баримт бичгийг дотоод сүлжээ ашиглан байршуулах байдлаар бичиг хэргийн зардалд 6522,0 мянган төгрөгийг зарцуулж 0,9 мянган төгрөг хэмнээд байна.<br>-Байгууллагын ашиглалтад байдаг суудлын автомашины засвар үйлчилгээний зардалд 832.8 төгрөг зарцуулж шатахууны зардлыг 2,667.2 мянган төгрөг хэмнэсэн.<br>-Ажилтан албан хаагчдын ажлын гүйцэтгэлийг хүрэх зорилтот түвшингээр нь үнэлж цалингийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урамшууллыг хагас жилийн байдлаар олгосон.<br>2) 11 дүгээр сарын байдлаар тус байгууллага нь үйл ажиллагааны зардалтай холбоотой ямар нэгэн өр төлбөр үүсээгүй болно.<br>Дулаан ашиглалтыг сайжруулах эрчим хүчний байгууллагаас өгсөн албан шаардлагын дагуу дулааны шугам хоолойн термометр менометр зэрэг багаж хэрэгсэл солих, дулааны узел шугамыг дулаалах хаалга солих ажлыг хийх саналыг БХСГазарт хүргүүлж төсвийн зохицуулалт хийлгэсэн.<br>Мөн бусад зардлыг батлагдсан төсвийн хүрээнд зардлын ангиллын дагуу зарцуулан 1601186,14 мянган төгрөгний гүйцэтгэл гарган ажиллаж байна.<br>3)Байгууллагын ажилтан албан хаагчдын цалин хөлс түүнээс суутган тооцсон нийгмийн даатгалын шимтгэлийн төлбөр, ХХОАТ-ын ямар нэгэн өр төлбөр үүсгэлгүй хуульд заасан хугацаанд нь холбогдох байгууллагуудын дансанд шилжүүлж тооцоо нийлсэн актаар баталгаажуулж байна. | |
| 2.1.11 | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд хүргүүлнэ. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр | Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээг нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн мэдээллийн системд бүртгэж хянан хугацаанд нь гаргаж хүргүүлсэн.<br>2024 оны эхний хагас жилийн сангийн санхүүгийн тайланг Core системээс үүсгэж шалгах балансын үзүүлэлттэй уялдуулан цаг хугацаанд нь гаргасан болно.<br>Байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн хагас жилийн тайлан *Green erp* санхүүгийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлагын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | авлагын сарын мэдээг үнэн [illegible]в гаргаж, хугацаанд нь хүргүүлсэн байна. | программаар хуулийн хугацаанд үнэн зөв гарган цахима[illegible] илгээж гүйцэтгэлийг ханган ажилласан болно. Тайлангийн тодруулга тайлбар, төрийн сангийн дансны үлдэгдлийн баталгаа, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн актын хамт Санхүү бүртгэлийн газарт цаасаар баталгаажуулан хүргүүлсэн.<br>Сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн зарлагын сарын мэдээ, өглөг авлагын мэдээ тайланг санхүүгийн программаас хөрвүүлэн сар бүрийн 01-ний дотор илгээн, НДЕГ-ын Санхүү бүртгэлийн газрын байгууллагын төсвийн гүйцэтгэл хариуцсан мэргэжилтэнд хянуулж, нэгтгүүлэн ажиллаж байна. ХНХЯ болон аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст сарын гүйцэтгэлийн мэдээ, өглөг авлагын мэдээг хүргүүлж ажилласан байна | |
| 2.1.12 | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнаж ажиллана. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах;<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн | -Газрын даргын 2024 оны А/02 дугаар тушаалаар томилогдсон тооллогын комиссын бүрэлдэхүүн байгууллагын эхний хагас жилийн үндсэн хөрөнгө, бараа материал, маягт үнэт цаасны тооллогыг тогтоосон хугацаанд зохион байгуулж тайланг Санхүү бүртгэлийн газарт хугацаанд нь хүргүүлсэн байна. Үүнд: барилга, байгууламж, нийтийн эзэмшлийн 9 нэр төрлийн 341 926.8 мянган төгрөг, авто тээврийн хэрэгсэл 1 ширхэг 69 800.0 мянган төгрөг, машин тоног төхөөрөмж 48 нэр төрлийн 120,956.8 мянган төгрөг, тавилга эд хогшил 45 нэр төрлийн 66,129.2 мянган төгрөг, биет бус хөрөнгө 5 ширхэг 3 103.3 мянган төгрөг, газар 44 000.0 мянган төгрөг нийт 645,916.1 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг байцаагч, ажилтнуудын эд хөрөнгийн бүртгэлийн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх;<br>-Хагас болон бүтэн жилийн тооллогоор үнэ тогтоолгох, шилжүүлэх, актлах, хөрөнгийн жагсаалтыг тогтоосон хугацаанд хүргүүлэх;<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь хүргүүлэх;<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах;<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем" програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах;<br>-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлсэн байна. | карттай тулгалт хийж хөрөнгүүдийг тоолсон.<br>Ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчдын эд хөрөнгийн бүртгэлийн картанд бүртгэлтэй хөрөнгүүдийг санхүүгийн программд үндсэн хөрөнгийн шилжилт хөдөлгөөн, өөрчлөлтийг тогтмол хөтлөн ажиллаж байна.<br>-Байгууллагын 2023 оны эд хөрөнгийн тооллогын тайлан, төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн бүртгэлийн маягтууд /ТӨХ1, ТӨХ2, ТӨХ3, ТӨХ4, ТӨХ5, ТӨХ6, ТӨХ7, ТӨХ11, ТӨЗ/, санхүү байдлын тайлан, үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй мэдээ, тайланг *pdf* хэлбэрээр тус тус ТӨБЗГ-ын *www.burtgel.pcsp.gov.mn* тооллогын программд 2024 оны 1 дүгээр улиралд багтаан оруулж, баталгаажуулан цаг хугацаанд нь илгээсэн.<br>***/Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас зохион байгуулсан сургалтад оролцож 2023 оны Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээ, хөрөнгийн хөдлөл өөрчлөлт, хадгалалт ашиглалт хамгаалалт, бүртгэл мэдээ тайлангийн биелэлтийг шалгуулж 97% үзүүлэлт авсан болно./***<br>-Эхний хагас жилийн тооллогоор элэгдлээрээ анхны өртгөө нөхөж цаашид ашиглах боломжгүй болсон 3 нэр төрлийн 21 ширхэг 585,0 мянган төгрөгийн шилмүүст мод, зүлэгжүүлсэн талбай, 10 нэр төрлийн 18 ширхэг 9,511.7 мянган төгрөгийн өртөгтэй компьютер, бусад тоног төхөөрөмж, 39 ширхэг 10,920.0 мянган төгрөгийн өртөгтэй сандал, 5 ширхэг 3,103.3 мянган төгрөгийн өртөгтэй | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын программ хангамж нийт 24,120.0 мянган төгрөгийн өртөгтэй хөрөнгийг актлуулах саналыг Санхүү бүртгэлийн газарт хүргүүлсэн байна. | |
| 2.1.13 | Төсвийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, Аудитын байгууллагаас "Өөрчлөлтгүй" дүгнэлттэй ажиллах. | | Өөрчлөлтгүй дүгнэлт авах, зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлнэ. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар өөрчлөлтгүй дүгнэлт авсан. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна. | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн Аудитын шалгалтаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авах. б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлсэн байна. | а)Нийгмийн даатгалын нэгдсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар "Өөрчлөлтгүй" дүгнэлт авч Санхүү бүртгэлийн газар аудитлагдсан тайланг хуульд заасан хугацаанд хүргүүлсэн.<br>б) Дээрх аудитын тайлангаар ажилтнуудын хувийн чөлөөний хүсэлтийг шийдвэрлэхдээ чөлөөтэй байх хугацааны нэмэгдэл цалин хөлсийг олгож тооцоолсон нь хууль тогтоомжтой нийцэхгүй байна гэсэн албан шаардлага авсан. Албан шаардлагын хүрээнд алдааг дахин гаргахгүйгээр хууль тогтоомжийг мөрдлөг болгон ажиллаж байна. | |
| 2.1.14 | Нийгмийн даатгалын ерөнхий газраас банкуудтай байгуулсан ерөнхий гэрээг хэрэгжүүлэх, дүгнэх, биелэлтийг НДЕГ-т хүргүүлэх. | | Нийгмийн даатгалын ерөнхий газраас арилжааны банкуудтай байгуулсан "Хамтран ажиллах гэрээ"-г хэрэгжүүлэн, хэрэгжилтийг дүгнэн НДЕГ-т хүргүүлнэ. | Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажилласан | а) Банкуудтай байгуулсан ерөнхий гэрээний хэрэгжилтийг хангаж ажиллах. б) Гэрээний хэрэгжилтийг дүгнэж, дүнг НДЕГ-т хүргүүлсэн байна. | Тус газар нь арилжааны банкуудтай "Хамтран ажиллах гэрээ"-ний хэрэгжилтийн хангаж ажиллаж байна.<br>Үүнд:<br>-Орлого зарлагын гүйлгээ, үлдэгдлийг интернэт банкаар харах эрхийн дагуу дансны хуулгыг тухай бүр нь харж АТМ, киокс,мобайл банкаар хийгдсэн утга тодорхойгүй гүйлгээнүүдийг жагсаалт гарган банканд хүргүүлж тодруулах арга хэмжээг авч ажиллаа.<br>-Банкууд нь төвлөрсөн орлогын харилцах дансны үлдэгдлийн өдөр бүр төвлөрүүлэн ажиллаж байна.<br>-Харилцах дансны өдөр бүрийн үлдэгдэлд жилийн 3 хувийн хүү тооцож сар бүрийн сүүлийн өдөр банкны | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүгийн орлогыг тооцож байна.<br><br>-Тэтгэвэр авагчдад олгох тэтгэвэр олголтын жагсаалтыг бэлтгэн сар бүрийн сүүлийн өдөр "Тэтгэвэр олголтын жагсаалтыг хүлээлцсэн тухай акт үйлдэн баталгаажуулж файлаа байршуулан сар бүрийн 1-ны дотор тэтгэвэр олгох арга хэмжээг хамтран хэрэгжүүлэн ажилласан.<br><br>-Тэтгэвэр авагчийн банкаар үйлчлүүлсэн үйлчилгээний хөлсийг 50 төгрөгөөр тооцож сар бүр тооцоо нийлэн нэхэмжилсэн дүнгээр банкинд шилжүүлж байна.<br><br>-Тэтгэмж авах даатгуулагчдын овог нэр, регистерийн дугаар тэтгэмжийн төрөл зэргийг тодорхой бичиж тэтгэмжийн зардал төлбөрийг, төлбөрийн хүсэлтээр шилжүүлэн гүйлгээг гаргаж байна. Дээрх гэрээний заалтуудын хүрээнд тус газар нь арилжааны банкуудтай хамтран ажиллахад ямар нэгэн бэрхшээл гараагүй болно.<br><br>Б)Арилжааны банкуудтай хамтран ажилласан 2023 оны гэрээг 2024 оны 1 сарын 10-ны дотор дүгнэж биелэлтийг хүргүүлсэн | |
| 2.1.15 | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | Холбогдох хууль тогтоомжийн дагуу мэдээллийг үнэн зөв оруулж бүртгэнэ. | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br>б) Ажил олгогч, | а)Нийгмийн даатгалын санд бүртгэгдсэн ажил олгогч, даатгуулагчийн урьдчилж төлсөн орлогыг харилцах дансны хуулганаас татаж үнэн зөв бүртгэж орлого таниулж байна. Урьдчилж орсон орлогыг ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл ногдуулалтын тайлантай тулгаж илүү дутуу төлсөн | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | даатгуулагчийн мэдээллийг үнэн зөв бүртгэж мэдээллийн сан бүрдүүлсэн байна | шимтгэлийг тухайн байгууллагын санхүүгийн ажилтанд тулган баталгаажуулж байна.<br>Албан журмын даатгал, сайн дурын даатгалтай давхцан төлөгдсөн 13 даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч холбогдох анхан шатны баримтад тулгуурлан засварлаж дараагийн сарын шимтгэлд нь тооцон суутгасан,<br>-Сайн дурын даатгал төлсөн боловч албан журмын даатгал давхацсан 22 иргэний хүсэлтийг хүлээн авч ХХТАОрлогоыг засварлан тухайн даатгуулагчийн харилцах дансанд шилжүүлсэн зэрэг залруулгуудыг хийсэн байна.<br>б) Оны эхнээс шинээр бүртгүүлэхээр хүсэлт гаргасан 111 ажил ажил олгогчийн оноосон нэр, бүртгэлийн дугаар зэрэг үндсэн мэдээллүүд давхардаж байгаа эхэсийг шалган, тухайн аж ахйун нэгжийн өмчийн хэлбэр, хаяг байршил, удирдах болон холбогдох ажилтны утасны дугаар, цахим хаяг, харилцах банкинд байрших харилцах дансны дугаар зэргийг бүрэн гүйцэд бүрдүүлэхэд анхааран ажиллж байна.<br><br>Мөн шимтгэл төлөгч аж ахуйн нэгж байгууллагын өмчийн хэлбэр, үйл ажиллагааны чиглэл, хаяг байршлын өөрчлөлт, цахим хаяг зэргийг ажил олгогчоос ирүүлсэн хүсэлтийн дагуу цаг тухайд нь шинэчилж байна.<br>Ажил олгогчийн улсын бүртгэлийн хаягт өөрчлөлт орж, шилжих хүсэлт гаргасан тохиолдолд дараах баримт бичиг, мэдээллийг үндэслэн шилжилт хөдөлгөөн хийгдэж байна. Үүнд:<br>1. Өөр аймаг, дүүрэгт шилжих тухай албан хүсэлт, | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар,<br>3. Шаардлагатай тохиолдолд итгэмжлэл,<br>Тооцоо нийлсэн акт зэргийн баримтуудыг үндсэлэн шилжилт хөдөлгөөнийг хийж байна. Ажил олгогчийн шилжилт хөдөлгөөнийг хийснээр бүртгэлийн дугаар өөрчдөгдөхгүй ба нийгмийн даатгалын шимгэлийн өр, авлагын тооцоог дуусгаж, тооцоо нийлсэн акт дараа шилжил хөдөлгөөнийг хийж дуусгаж байна<br>Жилийн эцсийн байдлаар албан хүсэлт ирүүлсэн 87 байгууллагын мэдээллийг шинэчлэсэн байна. | |
| 2.1.16 | Нийгмийн даатгалын мэдээллийн систем хөгжүүлэх" төслийн хүрээнд Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн шинэчлэлтэй холбоотой ажлыг хэрэгжүүлэх. | | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багтай хамтран Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлыг хийж гүйцэтгэнэ. | ХНХЯ-тай гэрээтэй Ай Ти Зон ХХК-ийн Төслийн багаас зохион байгуулсан ажлуудад оролцсон | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг "Core" системээр хөтлөх ажлын гүйцэтгэлийг хангаж ажилласан байна. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн дансны жагсаалтын дагуу бүтээгдэхүүн үйлчилгээний орлого зарлагын ажил гүйлгээ бүрийг холбогдох анхан шатны нотлох баримт, харилцах дансны хуулгыг үндэслэн бүртгэж байна.<br>Ажил олгогчоос төлсөн нийгмийн даатгалын шимтгэл, сайн дурын даатгуулагчаас төлсөн урьдчилж орсон орлогыг тухай бүрд нь бүртгэж мэдээллийг хянаж байна.<br>Тэтгэвэр, тэтгэмжийн зардлыг олгосон тухай бүрт банкны хуулгыг оруулж тэтгэвэр тэтгэмжийн өглөг хаах ажлыг тогтмол хийж байна.<br>Core системд гарсан алдааг хариуцсан байцаагчаар засуулах, болохгүй байгаа мэдээллийг шийдвэрлүүлэхээр НДЕГ-ын дэргэдэх Мэдээлэл тооцоолох төвд 6 удаа албан бичгээр, /sicosndaatgal.atlassian.net/ системээр 24 удаагийн хүсэлт хүргүүлэн засварлуулж байна. | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | баталгаажуулсан байна | | |
| 2.1.18 | ЭМД-ийн шимтгэлээ өөрөө хариуцан төлдөг даатгуулагчтай холбоотой өглөг авлагыг тооцоо нийлсэн актаар баталгаажуулж ЭМДЕГ-т хүргүүлэхтэй холбоотой холбогдох ажлуудыг хэрэгжүүлэх | | Эрүүл мэндийн даатгалын сангийн харилцах дансуудыг хаах, харилцах дансны үлдэгдэл болон тайлангаар гарсан авлага, өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулна. | | | 2024 эхний 5 хоногийн байдлаар бусад даатгуулагчаас төлсөн эрүүл мэндийн даатгалын хураамж 13069,9 мянган төгрөгийг төвлөрүүлэн тооцоо нийлж ажилласан.<br>2023 онд ЭМД хураамжтай холбоотой үүссэн авлага 12,6 мянган төгрөгийг барагдуулж тооцоо нийлсэн актаар баталгаажуулсан болно. | |
| *"Нийгмийн даатгалын үйлчилгээг мэдээллийн технологийн үйл ажиллагаагаар дэмжих, мэдээллийн сан бүрдүүлэлт, хадгалалт хамгаалалт, гадаад, дотоод мэдээллийн урсгалын нэгдсэн хяналттай тогтолцоог төлөвшүүлэх, хөгжүүлэх" гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:* | | | | | | | |
| 3.1.1 | Мэдээллийн сангийн бүрдүүлэлтийг сайжруулж, ажил олгогчоос ирүүлэх мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | | Ажил олгогчийн үндсэн мэдээллийг бүрэн гүйцэд бүрдүүлсэн байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан. | Ажил олгогчийн ЭЗҮАСА, татварын бүртгэлийн дугаарыг бүрэн бүрдүүлсэн байна | Нийгмийн даатгалын шинэчилсэн систем нь төрийн мэдээлэл солилцооны "Хур" системтэй холбогдсон байдаг.<br>Шинээр бүртгүүлэхээр хүсэлт гаргасан аж ахуйн нэгж байгууллагын удирдлагын мэдээллийг УБЕГ-ын мэдээллийн сангаас үнэн зөв татагдаж байгаа эсэхийг хянан, бүртгэн ажиллаж байна. Ажил олгогч байгууллагын удирдлага тус байгууллагын нягтлан бодогч, хүний нөөцийн ажилтны мэдээллийг шимтгэл ногдуулалтын программд оруулж, /portal.ndaatgal.mn/-д, нэвтрэх эрх олгон ажиллаж байна | |
| | | | Ажил олгогчийн НДШ-ийн тайланд ирүүлэх даатгуулагчийн мэдээллийг бүрэн, зөв бүрдүүлсэн байх | | -Даатгуулагчийн үндсэн мэдээллийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>-Даатгуулагчийн төрлийг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн улсын кодыг бүрэн, зөв хүлээн авсан байна.<br>- Даатгуулагчийн ажил мэргэжлийн ангиллыг бүрэн, зөв хүлээн авсан байна | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн гүйцэд шаардаж авсан байх | Ажил олгогчийн үндсэн мэдээллийн бүрдүүлэлт 99.94% байсан | Ажил олгогчоос цахимаар ирүүлэх тушаалын бүртгэлийг бүрэн, зөв гүйцэд шаардаж авсан байна. | | |
| 3.1.2 | Албан журмын болон сайн дурын даатгуулагчийн ногдуулалтын мэдээллийг үнэн зөв бүртгэсэн байх | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | | Албан журмын болон сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | Албан журмын даатгал сайн дурын даатгал давхацсан тохиолдолд тухайн даатгуулагчийн хүсэлтийг хүлээн авч засварлан төлсөн шимтгэлийг буцааж олгох мөн дараа сарын шимтгэлд нь суутган тооцож байна. | |
| | | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байх | | Сайн дурын даатгалыг нэг даатгуулагч дээр нэг сар дээр давхардуулан бүртгэхгүй байна. | Сайн дурын даатгалд хамрагдсан даатгуулагчийн гэрээг байгуулж нэхэмжлэл үүсгэн ногдуулалтыг хянаж байна. | |
| | | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байх | | Сайн дурын даатгуулагчийн ногдуулалтыг төлөлтөөс хэтрүүлж хийхгүй байна. | | |

## ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

| Д/д | Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ | Үр дүнгийн үзүүлэлт | |
|---|---|---|---|
| | | Хүрэх түвшин | Хүрсэн түвшин / биелэлт |
| 1 | 2 | 3 | 4 |
| | Төрийн албаны зөвлөлийн 7:4:10 арга зүйн сургалт болон төрийн албан хаагчийн цахим сургалтын платформд байршуулсан сургалтад тогтмол | Мэдлэг, ур чадвар, арга зүйд суралцсан байх, | Төрийн албаны зөвлөлөөс долоо хоног бүрийн Пүрэв гаригт зохион байгуулж байгаа 7:4:10 арга зүйн цахим сургалтыг тогтмол сонсож байна. Үүнд: Төрийн албаны шинэтгэл цэгрэх хөдөлгөөн, Төрийн албан хаагчийн цалин хөлс нийгмийн баталгаа, Байгууллагын хувь хүний санхүгийн төлөвлөлт удирдлага, Үндэсний монгол бичгийн |

| | | | |
|---|---|---|---|
| | хамрагдах | | мэдлэг тодорхойлох, Нийгмийн даатгалын хууль тогтоомжийн өөрчлөлт шинэчлэлт зэрэг сургалтуудад хамрагдсан. |
| | Үндэсний монгол бичгийн мэдлэг чадвараа сайжруулах | Ур чадварыг ахиулсан байх | Нийгмийн даатгалын ерөнхий газраас зохион байгуулсан Монгол бичгийн цахим сургалтад хамрагдсан. Мөн газрын ажилтнуудтай хамтран Монгол бичгийн танхимын анхан шатны сургалтад хамрагдаж байна.сургалта |
| | Нягтлан бодогчийн ахисан түвшний мэргэжлийн сургалтад хамрагдаж хугацаагүй эрхээ баталгаажуулах | Мэргэжил ур чадвараа ахиулсан байх | ММНБИнститутээс гишүүддээ зориулсан Ахисан түвшний санхүүгийн менежмент, Засаглал эрсдэл хяналтын 30 хоногийн сургалтад цахимаар суралцлаа.<br>Дээрх сургалтаар компанийн засаглал, хөрөнгө оруулалтын шийдвэо гаргалт, санхүүгийн төлөвлөлт хяналт эрсдэл, капиталын оновчтой бүтэц зэрэг мэргэжлийн ур чадварыг эзэмших, түүнийгээ байнга хөгжүүлэх, нягтлан бодох бүртгэл, аудит, хууль эрх зүй, санхүү татвар менежмент, мэдээллийн технологийн чиглэлийн мэдээллийг судалж мэдлэг чадвараа ахиулан ажиллалаа. |

*Төлөвлөгөөг үнэлсэн:*

ГАЗРЫН ДАРГА ........................ /Д.АРИУНБОЛД /

*Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн:*

ЗАХИРГАА ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА........................ /Б.ГАНХУЯГ/

*Тайлагнасан:* ***Нэгжийн дарга***

САНХҮҮ БҮРТГЭЛ, ХАМРАЛТ ОРЛОГЫН
ХЭЛТСИЙН ДАРГА ........................... /Б.БОЛОРТУЯА/

2024.12.10